БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Я.АМАРЖАРГАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ:

"СҮВЭН-УУЛ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ш.ШИНЭБААТАР

"ЭРҮҮЛ ШҮД-ЭРҮҮЛ ХҮҮХЭД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД НИЙЛҮҮЛЭГДЭХ ШҮДНИЙ ИЖ БҮРЭН КАБИНЕТ" НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №.550

Улаанбаатар хот

Нэг талаас "ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ" (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "СҮВЭН-УУЛ" ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. "Эрүүл шүд-эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлэгдэх шүдний иж бүрэн кабинет"-ийг нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 1,669,712,000.0₮ /Нэг тэрбум зургаан зуун жаран есөн сая долоон зуун арван хоёр мянга/ төгрөгөөр Улсын төсвийн хөрөнгөөс урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк	Тоо ширхэг
	1	2	3	4
1	Шүдний периапикаль зөөврийн рентген аппарат	Portable X-ray machine	Portable X-ray machine	32
2	Шүдний сандал	TS-TOP308	TS-TOP308	32
3	Шүдний суваг хэмжигч	WM-170	WM-170	32
4	Ломбо хатууруулагч гэрлийн аппарат	WM-208-B	WM-208-B	32

5	Хүчилтөрөгч өтгөруүүлэгч аппарат	Jay-5	Jay-5	32
6	Шүдний бор машины тосгүй компрессор	GM-1EW	GM-1EW	32
7	Шүлс соруулагч вакуум памп	TJ-750L	TJ-750L	32
8	Шүдний рентген сенсор	Dental x-ray Sensor	Dental x-ray Sensor	32
9	Шүдний вакум гар	A-5032	A-5032	32
10	Шүдний өрөмний бариул ариутгагч автоклав	FSF-12L	FSF-12L	32
11	Зөөврийн шүлс соруулагч аппарат /Отсос/	H002	H002	32
12	Шүдний чулуу, өнгөр цэвэрлэх чичиргээт машин	WM-155-A	WM-155-A	32
13	Хүүхдийн хөдөлгөөн хязгаарлагч хавтан	Papoose Board	Papoose Board	32
14	Хиймэл шүдний микромотор	AD-11	AD-11	32
15	Шүдний эмнэлгийн бүрэн автомат уурын автоклав	FSF-18L	FSF-18L	32
16	Багаж пакетлах, пакетлагч уут зүсэгч, наагч машин	AS-3010HCA	AS-3010HCA	32
17	Ус нэрэгч аппарат	FSF-100	FSF-100	32
18	Кварцын шүүгээ	MYB-519	MYB-519	32
19	Багаж угааж халдваргүйжүүлэгч ультросоник чичргээт машин	FSF-040S	FSF-040S	32
20	Шүдний хурдан эргэлтэд өрмийн бариул	High speed handpiece	High speed handpiece	32
21	Удаан эргэлтэт Push Button төрлийн өрмийн бариул	Low speed handpiece	Low speed handpiece	32
22	Шүдний эмнэлэгт хэрэглэгдэх үзлэгийн үндсэн ком багаж /толь, сэтгүүр, хямсаа, ломбоны багаж /	Dental tool kit	Dental tool kit	32
23	Шүдний эмнэлэгт хэрэглэгдэх мэс заслын тусгай багаж, бахь	Dental tool kit	Dental tool kit	32
24	Зөөврийн кварц	FY30I	FY30I	32
25	Зориулалтын тэргэнцэр	THR-MT010	THR-MT010	32

5. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хүчин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож, зөвшилцөн шийдвэрлэнэ.

6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Бусад шаардлагатай баримт бичиг;

Тендерийн баталгаа;

Тендер ба үнийн хуваарь;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь;

Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/

Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

7. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын дарга

Д.Нарантуяа

Захиргаа, хуулийн хэлтсийн дарга

С.Батбаатар

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий менежер

Г.Ганбаяр

Төслийн албаны дарга

О.Баярцэцэг

Санхүүгийн хэлтсийн дарга

Т.Хонгорзул

Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Бат-Эрдэнэ

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн газрын VIII байр, 1 давхар 106 тоот өрөө Улаанбаатар-48, Олимпын гудамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

Санхүү бүртгэлийн албаны дарга

О.Пүрэвсүрэн

Хаяг: УБ хот, БЗД, 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 46
Утас: 976-75756640
И-мэйл: contact@suven-uul.mn
Дансны дугаар: 5069363323
ХААН банк